

Дэлхийн талаарх Бурхны санаа зорилго —Хэсэг 3

jw.org сайтад байдаг «Библийн сургаалыг зөв ойлгох нь» номын 3-р бүлэгт үндэслэв.

ЗОРИЛГО: Юунд, ямар учраас итгэдгээ шалгаж, Библид юу гэж байдгийг судалж, итгэл үнэмшлээ бусдад хэрхэн тайлбарлахыг мэдэж аваарай.



ХҮМҮҮС БҮХ БЭРХШЭЭЛИЙГ АРИЛГАЖ ЧАДАХ УУ?

1 ИТГЭЛ ҮНЭМШЛЭЭ ШАЛГААРАЙ

Зарим хүн яагаад үгүй гэж хариулах бол?

.....

Зарим хүн яагаад тийм гэж хариулах бол?

.....

Чи өөрөө юу гэж хариулах вэ?

.....

Яагаад тэгж боддог вэ?

.....

Хүний засгийн газруудын хийж чадахгүй зүйлийг зөвхөн Бурхны Хаанчлал чадна.

(«Библийн сургаал» номын 3-р бүлгийн 13, 14-р догол мөрийг үзээрэй).

Даниел 2:44-ийг уншаарай.

Бурхны Хаанчлал хүний засгийн газруудаас хамаагүй давуу гэдгийг энэ зүйл хэрхэн баталдаг вэ?

.....

.....

Исаиа 9:6, 7-г уншаарай.

Энэ зөгнөлд бичсэнээр Бурхны Хаанчлалын Хаан яагаад тийм сайн Удирдагч байх вэ?

.....

.....



Хүүхдэд нь хэцүү санагдсан асуудлыг аав нь шийдэж өгдөг шиг, хүн төрөлхтөнд тулгараад байгаа хэцүү асуудлыг Ехова шийднэ

Бурхны Хаанчлал энэ ертөнцөд болж буй бүх асуудлыг шийднэ.

(«Библийн сургаал» номын 3-р бүлгийн 15–24-р догол мөрийг үзээрэй).

Исаиа 33:24; 65:21–25; Үйлс 24:15-ыг уншаарай.

Бурхны Хаанчлал хүн төрөлхтнийг захирдаг болох цагт амьдрал ямар байх бол?

Иохан 3:16; 17:3-ыг уншаарай.

Шинэ ертөнцөд амьдрах шаардлага хангахын тулд юу хийх ёстой вэ?

Чи шинэ ертөнцөд очоод юуг хамгийн түрүүнд үзмээр байна вэ? Яагаад?



ИТГЭЛ ҮНЭМШЛЭЭ ТАЙЛБАРЛААРАЙ

ХЭРЭВ ХҮН ...

Хүн төрөлхтөн өдөр ирэх бүр ахиц дэвшил гаргаж байна. Яваандаа бүх бэрхшээлийг арилгана.

... ГЭЖ ХЭЛБЭЛ ЧИ ЮУ ГЭЖ ХАРИУЛАХ ВЭ?

Хүн төрөлхтөн янз бүрийн салбарт ахиц дэвшил гаргасан нь үнэн. Гэхдээ Бурхан нэг ч хүний хийж чадахгүй зүйлийг бидний төлөө хийнэ. Бурхан удахгүй ...

.....
.....

Тэр хүнд Библийн аль зүйлийг үзүүлэх вэ?

.....

Тухайн хүн ямар үзэл бодолтойг санангаа тэр зүйлээ яаж эвтэйхэн тайлбарлах вэ?

.....

ХЭРЭВ ХҮН ...

Ирээдүйд одоогийнхоос илүү сайхан болно гэж горьдох хэрэггүй

... ГЭЖ ХЭЛБЭЛ ЧИ ЮУ ГЭЖ ХАРИУЛАХ ВЭ?

Ингэж боддог хүн олон байдаг байх л даа. Гэхдээ би тэгж боддоггүй. Яагаад гэвэл ...

.....
.....

Тэр хүнд Библийн аль зүйлийг үзүүлэх вэ?

.....

Тухайн хүн ямар үзэл бодолтойг санангаа тэр зүйлээ яаж эвтэйхэн тайлбарлах вэ?

.....